



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 5/32

Дархан

3.Эрдэнэбатыг ажилд томилох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, Дархан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 1-д дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 05/5912 тоот албан бичигт Зоригтын Эрдэнэбатыг "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ-ын даргын албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй байх тул 3.Эрдэнэбатыг уг албан тушаалд 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүлээлцүүлсүгэй.

Ахлагч: Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Л.Батчимэг

Гишүүд: Дархан хотын тохижилт үйлчилгээний газар  
ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер Н.Лхагвасүрэн

Дархан хотын тохижилт үйлчилгээний газар  
ОНӨААТҮГ-ын Нягтлан бологч Б.Мөнхцэцэг

Нарийн бичгийн дарга: Дархан сумын ЗДТГ-ын Орон сууц, гэр хороолол, аж үйлдвэржилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Одбаяр

3. 3.Эрдэнэбатын албан тушаалын нэг сарын үндсэн цалинг 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгөөр тогтоож, холбогдох нэмэгдэл, урамшууллыг хууль

4822060351  
D.ajil.Zahiramj-2022

тогтоомжийн дагуу тооцож олгохыг "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар"  
ОНӨААТҮГ-ын Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын  
мэдүүлгийг 30 хоногийн дотор эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэхийг  
3.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТУЛГАА